



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар Б/05

Мандалговь

Ундрахын Алтанчимэгийг  
ажилд түр томилох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 50.1.2 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.3, 64.5 дахь хэсгүүд, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5 дахь заалтууд, Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дугаар тогтоолын 10 дугаар хавсралт, Газрын дотоод журмын 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ундрахын Алтанчимэгийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр ажилд орох өргөдөл гаргасныг хүлээн авч Үйлчлэгч, зарлагын ажилд 2024 оны 02 дугаар сарын 06-ний өдрөөс эхлэн 3 сарын туршилтын хугацаагаар томилон ажиллуулсугай.

2.У.Алтанчимэгийн албан тушаалын үндсэн цалинг ТҮ-1 буюу 750,000 (долоон зуун тавин мянга) төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч (А.Нэргүй)-д зөвшөөрсүгэй.

3.Үйлчлэгч, зарлага У.Алтанчимэгийн ажил үүргийн хуваарь, байгууллагын дүрэм, журам, холбогдох бичиг баримтуудтай танилцуулан, хувийн хэргийг нь бүрдүүлэн авч, хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, үйлчлэгч, зарлагын ажил хүлээлцэхийг Ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батхүү)-д даалгасугай.

4.Холбогдох хууль, тогтоомж, газрын дүрэм, журмуудыг чанд сахин, идэвх зүтгэл гарган хариуцсан ажлаа чанартай гүйцэтгэж ажиллахыг (У.Алтанчимэг)-т үүрэг болгосугай.

5.Энэ тушаал гарсантай холбогдуулан тус Газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Б/09 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА



Tushaal B.docx

482401020